- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль УИХ-аас 2021 оны 6 дугаар сарын 11-нд батлагдаж, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын 2021 оны төлөвлөгөөнд нийт 71 ажил тусгагдсанаас 56 ажил бүрэн хэрэгжиж, ковид-19 цар тахлаас шалтгаалан Монгол улсад бүх нийтийн хөл хорионы онц байдал зарласан, Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийн дагуу төлөвлөгөөт бус шалгалтууд хийсэнтэй холбоотойгоор төлөвлөгөөнд тусгасан 15 ажил хэрэгжээгүй, үнэлэх боломжгүй байна.

Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс болон Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсээс Сангийн яамны 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сангийн яамны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 58,877,382.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 883,160.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сангийн яамны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,490,883.1 мянган төгрөгөөр буюу 1.3 дахин нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	31,783,005.3	38,050,931.1	6,267,925.8
Авлага	331,735.0	8,800,433.2	8,468,698.2
Урьдчилж гарсан тооцоо	242,216.7	269,673.9	27,457.2
Бараа материал	868,769.7	1,097,388.6	228,618.9
Бусад эргэлтийн хөрөнгө		448,673.6	448,673.6
Үндсэн хөрөнгө	15,104,803.3	16,154,312.8	1,049,509.5
Нийт хөрөнгө	48,330,530.0	64,821,413.2	16,490,883.2
Өр төлбөр	1,092,615.3	906,901.0	(185,714.3)
Хуримтлагдсан үр дүн	47,237,914.7	63,914,512.2	16,676,597.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	48,330,530.0	64,821,413.2	16,490,883.2

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоолоор төсвийн тухай хуульд батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гүйцэтгэл нь гараагүй байхад зардлаар хүлээн зөвшөөрч, ТЭЗ-ийн барьцаа дансанд төвлөрүүлсэн 16,474,491.1 мянган төгрөгөөр өмнөх оноос нэмэгдсэн;
- Авлага данс Засгийн газрын 2021 оны 406 дугаар тогтоолоор Коронавируст халдварын хариу арга хэмжээг эрчимжүүлэх ажлын хүрээнд олон улсын нислэгийн ачаа тээвэр, хилийн боомтуудаар импортын барааг татан авах, чингэлэг тээвэрлэлтийн үйл ажиллагааны санхүүжилтийг төрийн сангаас авах авлагаар бүртгэснээс нэмэгдсэн;
- Бараа материалын данс яамны хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж төсвийн хөрөнгөөр худалдан авсан 228,619.0 мянган төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн, программын лиценз зэргээс голлон нэмэгдсэн;
- Бусад эргэлтийн хөрөнгө данс яамны барилгын дээвэр болон 10 давхрын их засварын зардлаар нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгө данс өмнөх оноос өссөн нь урсгал зардлаас худалдан бэлтгэсэн 257,515.3 мянган төгрөг, гадаад зээлийн төсөл хөтөлбөрөөс үнэ төлбөргүй хүлээн авсан 2,218,535.6 мянган төгрөг, ТӨБЗГ-ын тушаал шийдвэрээр шилжүүлэн авсан барилга, тээврийн хэрэгсэл 571,190.0 мянган төгрөг, нийт 3,047,240.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын тушаал шийдвэрээр акталсан хөрөнгө 219,502.5 мянган төгрөг, бусад байгууллагад шилжүүлсэн 340,900.0 мянган төгрөгийн хөрөнгөөр буурсан;
- Өр төлбөр данс 185,714.3 мянган төгрөгөөр буурсан нь Засгийн газрын нөөц санд төлөх 268,048.2 мянган төгрөгийн МИАТ ХК-ийн тусгай нислэгийн тийзний үнийн зөрүү, барьцаа хөрөнгийн чөлөөлөлт зэргээс шалтгаалан буурсан;
- Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүн 16,676,597.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус яамны төсвийн хязгаар 17,611,585.4 мянган төгрөг, төсөв захирагч нь 2021 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 18,043,060.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар төсөв захирагчийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг анх 19,428,174.6 мянган төгрөгөөр баталж, 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 2 хөтөлбөрийн 20 арга хэмжээг санхүүжүүлэхээр 18,296,966.8 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 14,267,178.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 12,362,219.5 мянган төгрөгийг зарцуулж, 1,904,959.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 12,362,408.6 мянган төгрөг буюу 68.2 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 2,076,483.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 993,875.5 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 1,716,026.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн дутуу зарцуулалт нь санхүү, төсөв, эдийн засгийн нэгдсэн удирдлага 4,252,092.2 мянган төгрөг, санхүүгийн зах зээлийн зохицуулалт 1,522,466.0 мянган төгрөг бөгөөд 2 хөтөлбөрт тусгагдсан 4 арга хэмжээ хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
Батлагдсан төсөв			18,136,966.8	12,362,408.6	5,774,558.2	68.2
1	70202	Санхүү, төсөв, эдийн засгийн нэгдсэн удирдлага	14,611,587.5	10,359,495.3	4,252,092.2	70.9
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	7,102,570.0	5,626,756.5	1,475,813.5	79.2
1.2	80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ	1,416,385.3	1,357,935.7	58,449.6	95.9
1.3	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	17,690.0	12,980.0	4,710.0	73.4
1.4	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	322,083.6	317,138.6	4,945.0	98.4
1.5	80228	Цахим хуудасны бүртгэлийн хураамж	67,264.3	65,846.9	1,417.4	97.9
1.6	80509	Гадаадын болон олон улсын байгууллагуудын гишүүнчлэлийн хураамж	1,908,874.1	275,237.4	1,633,636.7	14.4
1.7	80704	Ахмад дайчин алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт	179,300.0	177,450.0	1,850.0	98.9
1.8	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	776,760.0	696,220.5	80,539.5	89.6
1.9	81547	Хөрөнгө оруулагчдын харилцааг идэвхжүүлэх	165,760.0	-	165,760.0	-
1.10	82324	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа	430,000.0	7,771.5	422,228.5	1.8
1.11	82902	Гадаад харилцааг эдийн засагжуулах	304,295.0	151,411.6	152,883.4	49.7
1.12	83105	Төсөл арга хэмжээний бэлтгэл хангах	900,000.0	876,505.9	23,494.1	97.4
1.13	83108	Төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй зардал	142,270.3	-	142,270.3	-
1.15	83110	Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлт	644,400.0	576,353.1	68,046.9	89.4
1.16	83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	13,603.9	-	13,603.9	-
1.17	83114	Блүмбергийн мэдээллийн системийн төлбөр	220,331.0	217,887.6	2,443.4	98.9
2	70204	Санхүүгийн зах зээлийн зохицуулалт	3,525,379.3	2,002,913.3	1,522,466.0	56.8
2.1	80216	Улсын зэрэглэл тогтоох үйлчилгээ	918,464.0	703,784.0	214,680.0	76.6
2.2	80220	Холбооны суваг ашигласны хөлс	1,406,915.3	1,299,129.2	107,786.1	92.3
2.3	80234	Ирээдүйн өв сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зардал	1,200,000.0	-	1,200,000.0	-

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яам нь 2021 онд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан 121,979.9 мянган төгрөг, Засгийн газрын нөөц хөрөнгөөс 13,709,704.8 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан доод шатны төсвийн захирагчд хуваарилсан 20,000.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 898.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг тус тус авсан байна.

Тайлант онд 5,177,306.4 мянган төгрөгийг зарцуулж, 8,675,276.8 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүлж, авлагаар бүртгэж тооцоо нийлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан Монгол Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв болон Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах ажлыг хуульд заасан хугацаанд буюу 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлаар Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийг 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталснаар хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан ажил 100 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Сангийн яамны хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 2 хөтөлбөрийн 20 арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж, зарцуулсан төсвийн гүйцэтгэл 68.2 хувийн биелэлттэй, зарцуулаагүй үлдэгдэл 5,774,558.2 мянган төгрөг байна.

Тайлант онд цар тахал, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан хэрэгжээгүй арга хэмжээний нийт 3,563,895.5 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна. Үүнд:

- Хөрөнгө оруулагчдын харилцааг идэвхжүүлэх, хөрөнгө оруулагчдад ЗГ-ын өрийн статистик мэдээлэл, танилцуулгын тогтмол хүргүүлэх, уулзалт, арга хэмжээ зохион байгуулах санхүүжилтэд 165,760.0 мянган төгрөг;
- Монгол Улсаас гадаад улс орнуудад суугаа элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтэд санхүүгийн хяналт шалгалт хийх санхүүжилтэд 142,270.3 мянган төгрөг;
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах төлөвлөгөө гаргах, шаардлагатай техник, туслалцаа, зөвлөх үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлэх санхүүжилтэд 1,200,000.0 мянган төгрөг;
- Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Европын холбооны техник туслалцааны үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх, жилийн уулзалтад оролцох, Монгол Улсыг Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэх, нэгдсэн тайлан боловсруулах санхүүжилтэд 422,228.5 мянган төгрөг;
- Засгийн газар, түнш орон, олон улсын банк, санхүүгийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, гишүүн орноор элсэх санхүүжилтэд 1,633,636.7 мянган төгрөг.

ЗГ-ын 2020 оны 250 дугаар тогтоолоор баталсан Сангийн яамны 110 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд түүхэн ном хэвлүүлэхэд 142,200.0 мянган төгрөг, тэмдэглэлийн дэвтэр худалдан авахад 19,800.0 мянган төгрөг, музей тохижуулахад 39,573.9 мянган төгрөг нийт 201,573.9 мянган төгрөгийн зарцуулалт гаргасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитын гол асуудалд хөндөх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод байршуулж, мэдээлсэн байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Сангийн яамны 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 40 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын нийт 59 ажил гүйлгээг мэдээлээгүй зөрчилд өгсөн 1 албан шаардлагын биелэлт 86.6 хувь, 402,435.8 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-			86.6
Зөвлөмж	5	402,435.8	5	402,435.8			90.0
Нийт дүн	6	402,435.8	6	402,435.8			88.3

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайланд 38,050,931.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлагнагдсанаас 37,169,419.8 мянган төгрөг нь ЗГ-ын 2019 оны 430, 2020 оны 253, 2021 оны 397 дугаар тогтоолоор төсвийн тухай хуульд батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гүйцэтгэл нь гараагүй байхад зардлаар хүлээн зөвшөөрч, ТЕЗ-ийн барьцаа дансанд төвлөрүүлсэн байна. Үүнээс тайлант хугацаанд хамаарах нь 16,474,491.1 мянган төгрөг байгааг дараагийн аудитаар авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 230,911.5 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 13,500.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 217,411.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 217,411.5 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 883,160.7 мянган төгрөгөөс 665,749.2 мянган төгрөгөөр бага тул Зөрчилгүй дүгнэлт өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах, ЗГ, УИХ-д өргөн мэдүүлэх чиг үүрэг бүхий концессын хуулийг хүчингүй болгох зайлшгүй хэрэгцээ байгааг олон нийтэд ойлгуулах контент бэлтгэхэд зориулан нэр бүхий 2 төрийн бус байгууллагатай нийт 27,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, урьдчилгаа төлбөрт 13,500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч үлдэгдэл төлбөрийг өглөгөөр бүртгэж тайлагнаагүй;

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Түүвэрт хамрагдсан ажил гүйлгээнээс 94,769.0 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрд хянаж ажиллах;

2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Сангийн яамны газруудын 2021 оны эхний хагас, жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээг чанарын өндөр үнэлгээгээр ханган биелүүлж, Монгол улсын эдийн засаг, санхүү, төсвийн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд үр бүтээлтэй ажилласан газрын ажилчдыг Сангийн сайдын 2021 оны 117, 234 дүгээр тушаалаар шагнагдаа шагнал, урамшууллыг хавтгайруулан олгож, нийт 55,256.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.2-т Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна, мөн 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн

зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Шагнал, урамшууллыг хавтгайруулан олгохгүй байх;

3. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Тайлант онд Засгийн газрын цом-2021 тэмцээнд 26,999.8 мянган төгрөг, фитнесийн дугуй 2 ширхгийг худалдан авахад 6,435.0 мянган төгрөг, Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах зорилгоор туршилтаар яамны Баянзүрх дүүрэгт амьдардаг албан хаагчдыг ажилд зөөхөөр Хоссанна ХХК-тай 4 сарын хугацаанд түрээсийн гэрээ байгуулж, нийт 8,480.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч ажилчдаас 177.2 мянган төгрөгийг суутгасан зэрэг нийт 41,914.8 мянган төгрөгийн үр ашиггүй зарцуулалт гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.4-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн хэмнэлтийн талаар гаргасан ЗГ-ын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зохистой удирдаж, үр ашигтай зарцуулах;

4. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Сангийн яам нь өөрийн цайны газрыг ажиллуулдаг Болорхутагту ХХК-тай байрны түрээсийн гэрээ байгуулаагүйгээс нийт 25,471.2 мянган төгрөгийн түрээсийн орлогыг бүрдүүлээгүй, түүний 40 хувь болох 10,188.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна", Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх" журмын 17-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төвлөрүүлж улсын төвлөрсөн төсөвт оруулна. Улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хувь, хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тогтооно" 19-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрийн эзэмшиж байгаа төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг бусдад түрээслүүлсэн бол энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж байх үүрэгтэй", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" 49 дүгээр тогтоолын хавсралтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын дагуу Болорхутагту ХХК-тай байрны түрээсийн гэрээ байгуулж, улсын төсөвт ногдох орлогыг төвлөрүүлж байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Сангийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн	
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																	
1	Сангийн яам	АХГ-2022/183/НА-СТА-ТШЗ	Нэр бүхий 2 төрийн бус байгууллагатай нийт 27,000.0 мянган төгрөгийн хуулийн төсөл сурталчлах контент бэлтгэх гэрээ байгуулж, урьдчилгаа төлбөрт 13,500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч үлдэгдэл төлбөрийг өглөгөөр бүртгэж тайлагнаагүй.	Санхүүгийн байдлын тайлангийн эцсийн үлдэгдэлд өглөг нэмж залруулан бүртгэсэн.	1	13,500.0	1	13,500.0									
2	Сангийн яам	АХГ-2022/183/НА-СТА-ТШЗ	Сангийн яам нь өөрийн цайны газрыг ажиллуулдаг Болорхутагту ХХК-тай байрны түрээсийн гэрээ байгуулаагүйгээс нийт 25,471.2 мянган төгрөгийн түрээсийн орлогыг бүрдүүлээгүй, түүний 40 хувь болох 10,188.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолын дагуу Болорхутагту ХХК-тай байрны түрээсийн гэрээ байгуулж, улсын төсөвт ногдох орлогыг төвлөрүүлж байх;	1	25,471.2									1	25,471.2	
3	Сангийн яам	АХГ-2022/183/НА-СТА-ТШЗ	Сангийн яамны газруудын 2021 оны эхний хагас, жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээг чанарын өндөр үнэлгээгээр ханган биелүүлж, үр бүтээлтэй ажилласан газрын ажилчдыг Сангийн сайдын 2021 оны 117, 234 дүгээр тушаалаар шагнахдаа шагнал, урамшууллыг хавтгайруулан олгож, нийт 55,256.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.	Шагнал, урамшууллыг хавтгайруулан олгохгүй байх;	1	55,256.5										1	55,256.5
4	Сангийн яам	АХГ-2022/183/НА-СТА-ТШЗ	Тайлант онд Засгийн газрын цом-2021 тэмцээнд 26,999.8 мянган төгрөг, фитнес дугуй 2 ширхгийг худалдан авахад 6,435.0 мянган төгрөг, Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах туршилтын ажлын хүрээнд ажилчдыг зөөвөрлөхөөр Хоссанна ХХК-тай 4 сарын хугацаанд автобусны түрээсийн гэрээ байгуулж 8,480.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч ажилчдаас 177.2 мянган төгрөгийг суутгасан зэрэг нийт 41,914.8 мянган төгрөгийн үр ашиггүй зарцуулалт гаргасан байна.	Төсвийн хэмнэлтийн талаар гаргасан ЗГ-ын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зохистой удирдаж, үр ашигтай зарцуулах;	1	41,914.8										1	41,914.8
5	Сангийн яам	АХГ-2022/183/НА-СТА-ТШЗ	Түүвэрт хамрагдсан ажил гүйлгээнээс 94,769.0 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.	Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрд хянаж ажиллах;	1	94,769.0										1	94,769.0
Дүн					5	230,911.5	1	13,500.0	-	-	-	-	-	-	-	4	217,411.5

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.